

## ОЮУТНЫ МӨНГӨНД ХАНДАХ ХАНДЛАГА, ХУВИЙН ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ СУДАЛСАН НЬ

*Д. Цэлмэг*  
*Магистр*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль*  
*Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

*tselmegke@yahoo.com*

*А. Нарангэрэл*  
*Доктор (Ph. D.),*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль*  
*Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

*naraatushi@yahoo.com*

**Хураангуй:** Орчин үед хувь хүний санхүүгийн боловсрол, мөнгөнд хандах хандлага цаашдын ажил амьдралын амжилтад чухал нөлөөтэй болсон. Энэ цаг үед оюутан залуус санхүүгийн боловсролоор дутагдаж, тэр нь оюутны амьдралын бэрхшээлтэй асуудал болж буй нөхцөл байдал ажиглагддаг. Оюутны мөнгөнд хандах хандлага ба хувийн хариуцлагатай байдлыг илрүүлэх зорилгоор асуулгын арга ашиглан судалгаа хийж үзэхэд оюутнуудын дийлэнх нь мөнгөнд хандах сөрөг болон дундаж хандлагатай байгаа нь харагдлаа. Харин хувийн хариуцлагатай байдал нь дийлэнх оюутанд харьцангуй сайн, эсвэл дундаж түвшинд байна. Хувийн хариуцлагатай байдал ба мөнгөнд хандах хандлага хооронд онцлог уялдаа холбоо харагдаагүй. Тиймээс хүүхдэд багаас нь эхлэн зорилготойгоор зохих санхүүгийн боловсрол олгож, мөнгөнд хандах эерэг хандлага төлөвшүүлэх нь хүүхдийн ирээдүйн амьдралд ач тустай.

**Түлхүүр үгс:** Санхүүгийн боловсрол, санхүүгийн зан үйл, хувийн хариуцлага, оюутны асуудал бэрхшээл

### УДИРТГАЛ

Зарим хүн мөнгийг өөрийн аюулгүй байдлын хэрэгцээтэй холбон харж байхад зарим нь эрх мэдэл, амжилтын үндэс болгон хардаг. Зарим хүнд мөнгө эрх чөлөөг олгодог бол зарим хүнд стресс, түгшүүр авч ирдэг. Мөнгө бидний өдөр тутмын зайлшгүй хэрэгцээ тул бидний мөнгөнд хандах хандлага бидний амьдралын чанарт шууд нөлөөлж байдаг зүйл юм. Орчин үед хувь хүнийг сайтар таньж мэдэх, ажлын байранд сонгон шалгаруулах зэрэгт тухайн хүний мэдлэг, чадвар, зан төлөвийн онцлогийг судлахын хажуугаар орчны аливаа юмс үзэгдэлд хандах хандлагыг нь (тухайлбал, ажил хөдөлмөрт хандах хандлага, бусад хүмүүст хандах хандлага, мөнгөнд

хандах хандлага гэх мэт) судалдаг болсон. Учир нь хувь хүний тухайн юмс үзэгдэлд хандах хандлага цаашдын зан үйл, сэтгэл хөдлөлийн байдалд чухал нөлөөтэй байдгийг сэтгэл судлаачид онцолдог болжээ.

Хүний мөнгөнд хандах хандлага бол эцэг эх, ойрын хүмүүсийн хүмүүжлийн арга барил, туулсан амьдралын туршлага зэргийн үр дүнд төлөвшин тогтдог, мөн зарим талаараа хувь хүний арвигч хямгагч, эмх цэгцтэй, хувийн хариуцлага өндөртэй зан чанаруудтай холбоотой байж болох, цаашид ажил амьдралын олон талбарт чухал нөлөөлөх бие хүний бүтцүүдийн нэг юм.

Мөнгөнд хандах хандлага нь тухайн хүний соёлын орчин, хүмүүжил, хувийн туршлага, үнэт зүйл зэргээс хамаарч хүн бүрт өөр байна. Гэхдээ энэ хандлага хүний хувийн үнэт зүйл, зорилгод нийцэж байдаг учраас мөнгөнд хандах “зөв” ба “буруу” хандлага гэж байхгүй гэдгийг дурьдах нь зүйтэй. Мөнгөнд хандах хандлагад нөлөөлж болох бас нэгэн сэтгэл зүйн хүчин зүйл бол насны онцлог юм. Залуу хүний хувьд ерөнхийдөө ойрын зорилго дээр төвлөрөх нь их байдаг учраас санхүүгийн шийдвэрүүдийг ч бас тийм хандлагаар гаргадаг байх магадлал өндөр. Ялангуяа оюутан залуу хүний хувьд мөнгө зарцуулалттай холбоотой асуудал бэрхшээл илүү их байж болзошгүйг 2020 онд хийсэн оюутнуудын өмнө тулгардаг сэтгэл зүйн түгээмэл асуудлуудыг илрүүлэх зорилготой судалгааны үр дүнгээс ажигласан юм. Дээрх судалгаанд нийт оролцогчдын 27% өөрийгөө мөнгө захиран зарцуулах чадваргүй гэж дүгнэсэн байв [1].

Тиймээс, эцэг эх, асран хүмүүжүүлэгч нар хүүхдүүдэд мөнгө зөв захиран зарцуулах болон мөнгөнд хариуцлагатай хандах талын мэдлэг, хүмүүжил олгож байгаа эсэх, мөн цаашид оюутнуудад энэ талын мэдлэг мэдээлэл олгох шаардлага бий эсэхийг тандан судлах хэрэгцээ байна гэж дүгнэв. Хэрэв хүний мөнгөнд хандах хандлагыг тодорхойлж чадвал санхүүгийн шийдвэр гаргах үйл явцуудыг тайлбарлах, урьдчилан таамаглах, илүү үр дүнтэй болгох боломжууд нээгдэж болох юм.

Залуучууд санхүүгийн боловсролтой (financial education) байх нь тэдний мөнгө захиран зарцуулах чадварт эергээр (financial literacy) нөлөөлж буйг өмнөх зарим судалгаа харуулсан нь бий [2].

Мөнгөнд хандах эрүүл, эерэг хандлага дараахь шинжүүдээр илэрнэ:

1. Мөнгийг хүндэлдэг: мөнгө олоход хүч хөдөлмөр зарцуулдгийг ойлгодог,
2. Өөрийгөө хянадаг, сахилга баттай: мөнгө үрэх, хадгалах, хөрөнгө оруулах шийдвэр гаргахдаа хариуцлагатай байдаг, тухайн үеийн сэтгэл хөдлөлд хэт автдаггүй,
3. Сэтгэл ханаж, талархаж мэддэг: өөрт байгаа зүйлсэд талархдаг, хэт материаллаг сэтгэлгээтэй биш,

4. Алсын хараатай: ирээдүйн санхүүгийн төлөвлөгөөтэй байдаг, түүндээ зорьж санхүүгийн шийдвэр гаргадаг, одоогийн таашаалдаа байнга дийлддэггүй,
5. Санхүүгийн боловсролтой байх: төсөв, өр, хөрөнгө оруулалт зэрэг санхүүгийн үндсэн ойлголтуудын тухай мэддэг байх зэрэг юм.

Дээрх хандлага, зан үйлүүдийг өөртөө бүрдүүлж чадсан хүний хувьд мөнгөтэй эрүүл, эерэг харилцаа тогтоох боломжууд нээгддэг.

Оюутнуудын өмнө тулгардаг сэтгэл зүйн түгээмэл асуудлуудыг илрүүлэх зорилготой судалгааны [1] үр дүнд санхүүгийн бэрхшээлийн тухай авч үзэхдээ, оюутантай ярилцсан ярилцлагаас жишээ авчээ. Тухайлбал, нэгэн оюутан “Оюутан хүн орлого гэх зүйлгүй ч өндөр зарлагатай байдаг. Сургалтын төлбөр, байрны төлбөрөөс гадна Улаанбаатар хотод амьдралын өртөг өндөр. Бид хоол, унаа, сурах бичиг, ном дэвтэрт байнга мөнгө зарж байдаг. Бас хааяа хувцас хэрэглэл авах, найз нөхөдтэйгээ гадуур уулзах хэрэгцээ байдаг. Аав ээжээсээ авч ирсэн мөнгөө зөв зохицуулж зарцуулж чадаагүйгээс болж сургалтын төлбөрөө төлж чадахгүйд хүрсэн хэд хэдэн найзууд ч байна даа. Цагийн ажил олж хийе гэж боддог боловч ажил олдохоосоо олдохгүй нь их байдаг” гэжээ.

Оюутнууд мөнгө захиран зарцуулах мэдлэг, туршлага багатай, мөн хөдөө орон нутгаас ирсэн оюутнуудын хувьд сар бүр тогтмол орлого гэхээс илүү нэг удаадаа их мөнгө аав ээжээсээ авч ирдэг байдал нь санхүүгийн гол асуудлуудыг үүсгэдэг байх магадлалтай. Дээрх судалгааны “Энгийн амьдралын зардал мөнгө хүрэлцдэггүй” гэсэн өгүүллийг нийт судалгаанд оролцогчдын 29% хүлээн зөвшөөрч, “Би мөнгөө зохицуулж, төлөвлөж, амьдралдаа хүргэж чаддаггүй” гэсэн өгүүллийг 27% зөвшөөрчээ.

## **ОНОЛ, АРГА ЗҮЙ БА СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

### **Судалгааны зорилго:**

Энэхүү судалгааг оюутан залуусын мөнгөнд хандах хандлага, хувийн хариуцлагатай байдлыг илрүүлэх зорилгоор дараахь зорилтуудын хүрээнд хийж гүйцэтгэсэн.

1. Оюутны мөнгөнд хандах хандлагыг тодорхойлох
2. Оюутны хувийн хариуцлагатай байдлыг тодорхойлох
3. Оюутны мөнгөнд хандах хандлага ба хувийн хариуцлагатай байдлын холбоо хамаарлыг илрүүлэх
4. Эцэг эх, асран хамгаалагч, сурган хүмүүжүүлэгч нарт зориулсан зөвлөмж боловсруулж гаргах

### **Судалгааны арга:**

Судалгааг асуулгын аргаар явуулж, статистик боловсруулалтыг SPSS програм ашиглан хийсэн. Судалгаанд ШУТИС-д сурч буй, голчлон 1 болон 2-аар курст суралцаж буй 182 оюутныг хамруулсан.

Асуулгад хувь хүний мөнгөнд хандах хандлага ба хувийн хариуцлагатай байдлыг тодорхойлох зорилго бүхий нийт 11 асуулт ашигласан. Асуултуудыг мөнгөнд хандах зөв зохистой (эрүүл, эерэг) хандлагыг илэрхийлэх шинж тэмдгүүдийг илрүүлж болохуйц байдлаар оюутнуудын өдөр тутмын амьдралд ойр жишээнүүд дээр зохиосон. Мөнгөнд хандах хандлагын тухай асуултууд нь:

1. *Танаас 1000 төгрөг зээлсэн танил чинь танд заавал буцааж өгөх ёстой юу?*
  - a. *Тийм*
  - b. *Үгүй*
2. *Та азын сугалаагаар сүүлийн үеийн загварын том дэлгэцтэй зурагт хожвол одоо байгаа зурагтаа яах вэ?*
  - a. *Тандаг хүнд бэлэглэнэ*
  - b. *Танихгүй хүнд зарна*
3. *Та НӨАТ-ын сугалаагаар их мөнгө хожвол юунд зарцуулах вэ?*
  - a. *Аялалд явна*
  - b. *Хадгаламжинд хийнэ*
4. *Мөнгө юутай илүү их холбоотой вэ?*
  - a. *Чөлөөт цаг ба тав тух*
  - b. *Үүрэг хариуцлага*
5. *Та пүүз авна гэж төлөвлөөгүй боловч дэлгүүрт “мааш” гоё пүүз байв. Та...*
  - a. *Худалдаж авна*
  - b. *Хараад л өнгөрнө*


Хувийн хариуцлагатай байдлын тухай асуултууд нь:

1. *Та утасны дугаараа хэдэн удаа сольж байсан бэ?*
  - a. *Бараг сольж байгаагүй*
  - b. *Олон удаа сольсон*
2. *Таны хичээл тасалдаг шалтгаан юу байдаг вэ?*
  - a. *Хичээл тасалдаггүй*
  - b. *Онцын шалтгаангүйгээр тасалдаг*
3. *Би өөрийгөө нас биед хүрсэн, бие даасан хүн гэж боддог.*
  - a. *Тийм*
  - b. *Үгүй*
4. *Таны бодлоор онц сурлагатнууд яагаад онц сурдаг вэ?*
  - a. *Тэд багш нарын хайрыг татаж чаддаг*
  - b. *Тэд хичээлээ сайн хийдэг*
5. *Олон нийтийн газар мөрдөх дүрэм журмууд танд ямар сэтгэгдэл төрүүлдэг вэ?*
  - a. *Эерэг*
  - b. *Сөрөг*
6. *Би хариуцлагатай хүн*
  - a. *Тийм*
  - b. *Үгүй ... зэрэг юм.*

### **Судалгааны үр дүн:**

Судалгааны үр дүнг танилцуулбал


Мөнгөнд хандах хандлагын тухайд:



Мөнгөнд хандах сөрөг хандлагатай 71 оюутан (39.01%)

Мөнгөнд хандах дундаж хандлагатай 64 оюутан (35.16%)

Мөнгөнд хандах эерэг хандлагатай 47 оюутан (25.82%) тус тус байв.



Харин хувь хүний хариуцлагын хувьд:

Хувийн хариуцлага сул 21 (11.53%) оюутан,

Хувийн хариуцлага дундаж 100 (54.94%) оюутан,

Хувийн хариуцлага өндөр гэж харж болох 61 (33.51%) оюутан байв.

Хувийн хариуцлагатай байдал ба мөнгөнд хандах хандлагын харилцан хамаарлын хувьд:

Хоёр хувьсагч харилцан хамааралтай байсан тохиолдол 60 (32.9%), харин харилцан хамааралгүй тохиолдол 122 (67.1%) байлаа. Иймээс оюутны хувийн хариуцлагатай байдал ба мөнгөнд хандах хандлагын хооронд мэдэгдэхүйц хамаарал байхгүй гэж үзэв.

## ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнгээс дүгнэхэд судалгаанд оролцогч оюутнуудын дунд мөнгөнд хандах сөрөг хандлага давамгайлж байна. Энэ нь оюутнууд насанд хүрч буй, хүүхэд настай нь харьцуулахад харьцангуй бие даасан хүмүүс боловч мөнгө зөв захиран зарцуулах чадвар муутай байгааг харуулна. Оюутны мөнгө захиран зарцуулах чадвар муу, санхүүгийн боловсролгүй, мөнгөнд хандах эрүүл бус хандлагатай байгаа нь өдөр

тутмын амьдралд олон бэрхшээл үүсгэж, цаашлаад стрессийн түвшин их байх, сурлагын амжилт ахицгүй байх нэг шалтгаан болж болзошгүй юм.

Харин хувь хүний хариуцлагын түвшний хувьд, оюутнууд сул биш байгааг илрүүлэв. Дийлэнх оюутан хариуцлагын түвшин өндөр, эсвэл дундаж байна. Залуу оюутан хүмүүсийн хувьд энэ нь их үнэлүүштэй.

Хамгийн сонирхолтой нь, дээрх хоёр хувьсагчийн хоорондын хамаарал их бага байгаа үр дүн гарсан явдал юм. Хэдийгээр хувь хүн хариуцлагатай, сахилга баттай шинж чанартай ч хэрэв мөнгө санхүүгийн тухай зааж сургаж байгаагүй бол мөнгөнд хандах эрүүл, эерэг хандлага төлөвшдөггүй байж болно. Хүүхэд байх үеэс эхлэн санхүүгийн боловсрол олгох, мөнгөтэй харьцахад сургах зэрэг нь тухайн хүүхэд насанд хүрэх үедээ мөнгөнд хандах эерэг хандлагатай болоход нөлөөлөх магадлалтай. Мөн “Миний хүү сахилга баттай хүү учраас мөнгийг хамаагүй үрэхгүй” гэх мэт өнгөц дүгнэлт хийх нь учир дутагдалтай болохыг харууллаа.

**Эцэг эх, асран хамгаалагч, сурган хүмүүжүүлэгч нарт зөвлөх нь:**

Хүүхдэд аль болох бага наснаас нь эхлэн мөнгөтэй харилцах тухай мэдлэг, туршлага олгох нь зүйтэй. Хүүхдийн бие даасан, томоотой, сахилга баттай зэрэг бусад шинж чанарыг харж өөрөө мөнгөтэй харьцах чадвартай болно гэж урьдчилан таамаглах нь үр дүн багатай.

Хүүхдэд мөнгөнд хандах эерэг хандлага төлөвшүүлэх зарим арга барилаас дурьдвал,

- Хүүхдээ тоо мэддэг болсон цагаас бага багаар мөнгө өгч явуулах, бие даан худалдан авалт хийх боломж олгох, юуг худалдан авахыг өөрөөр нь шийдүүлэх зэрэг туршлага суулгах

- Хүүхэдтэй тоглож байх үедээ мөнгөний тухай ярьж ойлгуулах, мөн мөнгөний асуудал шийдэх сэдвээр тоглоом тоглох

- Эцэг эх, асран хүмүүжүүлэгчид өөрсдөө мөнгөнд гамтай байх, хэлсэн үгэндээ хүрдэг байх зэрэг нь хүүхдэд том үлгэр дууриалал болдог

- Хүүхдээр өөрт нь таарсан жижиг зорилго тавиулж, тэр зорилгын төлөө мөнгө хуримтлуулах аян өрнүүлж байх зэрэг юм.

Эцэг эх, асран хамгаалагчдын сургаж хүмүүжүүлсэн байдал хүүхдийн ирээдүйн мөнгөнд хандах хандлагыг тодорхойлдог.

## **НОМ ЗҮЙ**

[1]. Д. Цогзолмаа, А. Нарангэрэл “Оюутан насанд тохиолдох сэтгэл зүйн асуудал” ШУТИС, БУХС-ийн сэтгэл зүйн төв, 2018

[2]. Д. Цэлмэг “Хөдөө орон нутгаас оюутан болж хотод ирсэн 1-р курсын оюутнуудын өмнө тулгардаг сэтгэл зүйн түгээмэл асуудлууд”, Нийгмийн хөгжил: асуудал, шийдэл ЭШӨ-ийн эмхэтгэл, 2020

[3]. John G. Lynch et al. “Financial literacy, financial education, and downstream financial behaviors”, *Management Science*, 2014

[4]. <https://economictimes.indiatimes.com/wealth/plan/8-ways-to-instil-healthy-money-attitude-in-your-children>